



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/19

Мөрөн сум

Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн
тооллого зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.5, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор баталсан "Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам", Соёлын сайдын 2023 оны А/317 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн өмчийн түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Тооллогыг батлагдсан удирдамжийн дагуу удирдлага, арга зүйгээр хангаж үр дүнтэй зохион байгуулж, тайлан мэдээг 2024 оны 10 дугаар сарын 01-ний дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Батбилгүүн) -д даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр
сарын 17-ний өдрийн А/19 дугаар
захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Батбилгүүн - (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүдэд:

Г.Нарангэрэл – (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн
мэргэжилтэн)

Х.Баасансүрэн – (Аймгийн Соёл урлагийн газрын Соёл
урлагийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Базаррагчаа – (Аймгийн Соёл урлагийн газрын
Соёлын хяналтын Улсын байцаагч)

Л.Одгэрэл – (Аймгийн Соёл урлагийн газрын
мэргэжилтэн)

Х.Рагчаа – (Аймгийн Төв музейн захирлын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч)

М.Одмаа – (Аймгийн Төв музейн эрдэм
шинжилгээний ажилтан)

Н.Дэлгэрмөрөн- (Аймгийн Төв музейн арга зүйч)

Х.Баасанхүү - (Аймгийн Төв музейн сан хөмрөгч)

Нарийн бичгийн дарга:

Д.Зулзаяа- (Аймгийн Төв музейн бүртгэл
мэдээллийн санч)

_____оОо_____